

# ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР




## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/09/-НА-СТА-ОНТС

|                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|-------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Говь-Алтай аймаг<br>Алтай хот<br>2021 он | Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга<br>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 70483413 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 70484055 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a><br>Ахлах аудитор: Ж.Бүжинханд<br>Утас: 70484030 Цахим хаяг: <a href="mailto:Bujinkhandj@audit.gov.mn">Bujinkhandj@audit.gov.mn</a> |
|-------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Агуулга

|                                                                            |   |
|----------------------------------------------------------------------------|---|
| 1. Аудитын санал дүгнэлт .....                                             | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                 | 3 |
| 3. Аудитын тайлан .....                                                    | 5 |
| 3.1 Ерөнхий зүйл .....                                                     | 5 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....                       | 5 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                            | 6 |
| 3.4 Материаллаг байдал .....                                               | 6 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....                                  | 6 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....                       | 6 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....                  | 7 |
| 3.8 Аудитын гол асуудал .....                                              | 7 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 7 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                                      | 7 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                             | 7 |
| 4. Аудитын илрүүлэлт .....                                                 | 8 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....                          | 8 |

## Товчилсон үгийн жагсаалт

|        |                                               |
|--------|-----------------------------------------------|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТА    | Санхүүгийн тайлангийн аудит                   |
| ОНТС   | Орон нутгийн төсөл сан                        |
| НА     | Нийцлийн аудит                                |



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ТАЙШИР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Г.БОЛОРМАА ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 24  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Тайшир сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07322181

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөг/

| Код   | Үзүүлэлт                                    | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------|---------------------------------------------|----------------|-----------------|
| 1     | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН                     | 206,403,544.98 | 221,510,268.13  |
| 31    | МӨНГӨН ХӨРӨНГӨ                              | 8,810,271.13   | 39,646,488.13   |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө                  | 8,810,271.13   | 39,646,488.13   |
| 31210 | Төгрөг                                      | 8,810,271.13   | 39,646,488.13   |
| 31211 | Төрийн сангийн харилцах                     | 8,810,271.13   | 39,646,488.13   |
| 33    | АВЛАГА                                      | 197,593,273.85 | 181,863,780.00  |
| 33400 | Зээлийн хүүгийн авлага                      | 693,650.85     | 309,907.00      |
| 33600 | Зээлийн авлага                              | 196,899,623.00 | 181,553,873.00  |
| 33610 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага  | 196,899,623.00 | 181,553,873.00  |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл                   | 196,899,623.00 | 181,553,873.00  |
| 3     | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II                 | 206,403,544.98 | 221,510,268.13  |
| 4     | НИЙТ ӨР ТӨЛБӨР                              | 0              | 10,064,400.00   |
| 41    | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                   | 0              | 10,064,400.00   |
| 41300 | Өглөг                                       | 0              | 10,064,400.00   |
| 41360 | Бусад өглөг                                 | 0              | 10,064,400.00   |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг                    | 0              | 10,064,400.00   |
| 5     | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН                    | 206,403,544.98 | 211,445,868.13  |
| 51    | Засгийн газрын хувь оролцоо                 | 206,403,544.98 | 211,445,868.13  |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн                        | 206,403,544.98 | 211,445,868.13  |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн                          | 201,645,642.13 | 206,403,544.98  |
| 51220 | Тайлант үеийн үр дүн                        | 4,757,902.85   | 5,042,323.15    |
| 6     | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 206,403,544.98 | 221,510,268.13  |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код     | Үзүүлэлт                                        | ӨМНӨХ ОН     | ТАЙЛАНТ ОН   |
|---------|-------------------------------------------------|--------------|--------------|
| I       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                 | 5,257,902.85 | 5,042,323.15 |
| 12      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                             | 5,257,902.85 | 5,042,323.15 |
| 120     | Нийтлэг татварын бус орлого                     | 5,257,902.85 | 5,042,323.15 |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого                | 5,257,902.85 | 5,042,323.15 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих       | 4,688,702.00 | 4,838,231.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих       | 569,200.85   | 204,092.15   |
| II      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                     | 500,000.00   | 0            |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ                                   | 500,000.00   | 0            |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                 | 500,000.00   | 0            |
| 2104    | Хангамж, бараа материалын зардал                | 500,000.00   | 0            |
| 210402  | Тээвэр, шатахуун                                | 500,000.00   | 0            |
| III     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)           | 4,757,902.85 | 5,042,323.15 |
| VI      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 4,757,902.85 | 5,042,323.15 |

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт                              | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|-------------------|----------------------------------------|
| 1   | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 201,645,642.13    | 201,645,642.13                         |
| 3   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 201,645,642.13    | 201,645,642.13                         |
| 9   | Тайлант үеийн үр дүн                  | 4,757,902.85      | 4,757,902.85                           |
| 10  | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 206,403,544.98    | 206,403,544.98                         |
| 11  | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл   | 206,403,544.98    | 206,403,544.98                         |
| 13  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 206,403,544.98    | 206,403,544.98                         |
| 19  | Тайлант үеийн үр дүн                  | 5,042,323.15      | 5,042,323.15                           |
| 20  | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 211,445,868.13    | 211,445,868.13                         |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код     | Үзүүлэлт                                               | ӨМНӨХ ОН       | ТАЙЛАНТ ОН     |
|---------|--------------------------------------------------------|----------------|----------------|
| I       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)                 | 59,335,630.00  | 117,771,817.00 |
| 12      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                    | 59,335,630.00  | 117,771,817.00 |
| 120     | Нийтлэг татварын бус орлого                            | 59,335,630.00  | 117,771,817.00 |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого                       | 59,335,630.00  | 117,771,817.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих              | 59,327,035.00  | 117,771,817.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих              | 8,595.00       | 0.00           |
| II      | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                      | 500,000.00     | 0              |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ                                          | 500,000.00     | 0              |
| 2104    | Хангамж, бараа материалын зардал                       | 500,000.00     | 0              |
| 210402  | Тээвэр, шатахуун                                       | 500,000.00     | 0              |
| III     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)    | 58,835,630.00  | 117,771,817.00 |
| VII     | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -54,000,000.00 | -86,935,600.00 |
| 23      | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ             | 54,000,000.00  | 86,935,600.00  |
| 230001  | Эргэж төлөгдөх зээл                                    | 54,000,000.00  | 86,935,600.00  |
| VIII    | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)      | 4,835,630.00   | 30,836,217.00  |
| 101     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл       | 3,974,641.13   | 8,810,271.13   |
| 20      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл      | 8,810,271.13   | 39,646,488.13  |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код    | Үзүүлэлт                                          | Төлөвлөгөө    | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|--------|---------------------------------------------------|---------------|-----------------------------|
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                 | 88,861,100.00 | 86,935,600.00               |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ                                     | 1,925,500.00  | 0                           |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                   | 1,925,500.00  | 0                           |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал                  | 770,200.00    | 0                           |
| 210402 | Тээвэр, шатахуун                                  | 770,200.00    | 0                           |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                   | 1,155,300.00  | 0                           |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                 | 1,155,300.00  | 0                           |
| 23     | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ        | 86,935,600.00 | 86,935,600.00               |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл                               | 86,935,600.00 | 86,935,600.00               |
| III    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                    | 88,861,100.00 | 117,771,817.00              |
| 35     | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС             | 88,861,100.00 | 117,771,817.00              |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих         | 3,850,900.00  | 117,771,817.00              |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих         | 76,200,000.00 | 0.00                        |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих                     | 8,810,200.00  | 0                           |
| 350004 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих                   | 0             | 0                           |
| 4      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0             | 8,810,271.13                |
| 5      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0             | 39,646,488.13               |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Тайшир сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Сум хөгжүүлэх сан нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам” батлагдсан. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулахаар журамлагдсан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Харин Монгол банкны мэдээллийн системд Сум хөгжүүлэх сангийн зээлдэгчийн зээлийн мэдээллийг оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Говь-Алтай аймгийн Тайшир сумын Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Сум хөгжүүлэх сан нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд сангаас олгосон зээл нь 3 жил төлөгдөхөөр авлага үүсгэж байгаа тул материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүн болох 206.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 221.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Сангийн хөрөнгийг сумдад жижиг дунд үйлдвэрлэл шинээр байгуулах буюу үйл ажиллагааг өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулахаар байна.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Сум хөгжүүлэх санд оны эхэнд 8.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд 117.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлого орж, 86.9 сая төгрөгийн зээл нэмж олгосон байна. Тайлант оны эцэст дансандаа 39.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу мөнгөн хөрөнгө 30.8 сая төгрөгөөр өссөн байна.

Авлагын эхний үлдэгдэл 197.6 сая төгрөг байсан бол тайлант хугацааны эцэст 181.8 сая төгрөг болж 15.8 сая төгрөгөөр буурсан байгаа нь сангаас олгосон зээлийн эргэн төлөлт сайн байгаатай холбоотой.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 206.4 сая төгрөг болж 5.0 сая төгрөгөөр өссөн нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу хүүгийн орлогыг тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэгтэй холбоотой. Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Сум хөгжүүлэх сангийн тухайд төсвийн төсөл хийгдээгүй байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Сум хөгжүүлэх сангийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй нь холбоотой жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2021 онд 88.8 сая төгрөгийн төсөв батлагджээ.

Төсвийн гүйцэтгэлээс үзэхэд үндсэн зээлийн болон хүүгийн орлогын төлөвлөгөөг 37.7 сая төгрөгөөр давуулсан нь зээлийн эргэн төлөлттэй холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сум хөгжүүлэх санд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Сум хөгжүүлэх сангийн 2021 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг хугацаандаа бүрэн мэдээлжээ. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь сангийн үйл ажиллагаанд 2012 онд гүйцэтгэлийн аудит, 2014, 2018 онд нийцлийн аудит, 2014 оноос хойш жил бүр санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг хийсэн.

Өмнөх аудитаар нийт 91.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 90.8 сая төгрөгийг төлүүлж, 1.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Цаашид хэрэгжээгүй аудитын шийдвэрийн үлдэгдлийг бүрэн барагдуулж биелэлтийг ирүүлэх хэрэгтэй.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар зээлдэгчийн авлагын дэлгэрэнгүй тайлан, тооцоо нийлсэн акт, хууль хяналтын байгууллагын шийдвэр, гэрээ, гэрээний хэрэгжилт, аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг үзэх нь зүйтэй.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 24.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21.2 сая төгрөгийн алдааг залруулж, 3.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой 21.2 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

### **4.2 Төлбөрийн акт**

Гэрээт хугацаанд Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдээр 3.7 сая төгрөгийн зээлийг төлүүлээгүй нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралт "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2-т "Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

### **4.3 Албан шаардлага**

Зээлийн гэрээний хугацаа дууссан 1 зээлдэгчдээс 2.5 сая төгрөгийн зээлийг Шүүхэд хандаж шийдвэр гаргуулаагүй нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралт "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5.3-т "Сумын Засаг дарга нь энэ журмын 3.5.2-т заасан төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй зохих журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

### **4.4 Зөвлөмж**

Аудитаар менежментийн захидал өгсөнгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр               | Нийт алдаа, зөрчлийн |      | Үүнээс    |      |               |     |                 |     |         |     |
|---|---------------------------------------------------|----------------------|------|-----------|------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|   |                                                   |                      |      | Залруулга |      | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|   |                                                   | Тоо                  | Дүн  | Тоо       | Дүн  | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| 1 | Говь-Алтай аймгийн Тайшир сумын Сум хөгжүүлэх сан | 3                    | 24.9 | 1         | 21.2 | 1             | 3.7 | 1               | 0   |         |     |